

ТЭЭВРИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬ

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл. Хуулийн зорилт**

1.1. Энэ хуулийн зорилт нь тээврийн нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл. Тээврийн тухай хууль тогтоомж**

2.1.Тээврийн ерөнхий хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон Автотээврийн тухай хууль, Авто замын тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Иргэний хууль тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актуудаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

**3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1. Энэ хууль нь тээврийн харилцан уялдааг хангах, тээврийн нэгдсэн сүлжээг бий болгох, холимог тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хамаарна.

**4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо**

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. **“ачаа”** гэж тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй эд зүйлс, бараа, мал, амьтан;

4.1.2. **“шинжлэн шалгах”** гэж тээвэрлэлтийн осол, зөрчилтэй холбоотойгоор мэдээлэл цуглуулах, дүгнэлт хийх, шалтгааныг тогтоон аюулгүй ажиллагааны зөвлөмж боловсруулах, үйл ажиллагааг;

4.1.3. **“зорчигч”** гэж тээврийн хэрэгслээр гэрээгээр /тасалбар/ зорчиж байгаа этгээдийг;

4.1.4. **“тээвэрлэлт”** гэж тээврийн хэрэгслээр ачаа болон зорчигчийг нэг газраас нөгөө газарт шилжүүлэн зөөх үйл ажиллагааг;

4.1.5. **“тээвэр”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээ, тэдгээрийн зохион байгуулалт, технологийн харилцан уялдаа бүхий ажил, үйлчилгээг;

4.1.6. **“тээврийн хэрэгсэл”** гэж Автотээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хуулиар тодорхойлсон нэр томъёогоор ойлгоно;

4.1.7. **“тээвэрлүүлэгч”** гэж тээвэрлэлт гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан этгээдийг;

4.1.8. **“тээвэрлэгч”** гэж тээвэрлэлтийг гэрээний дагуу тээвэрлэх үүрэгтэй, эрх бүхий хуулийн этгээдийг;

4.1.9. **“тээврийн дэд бүтэц”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зориулагдсан технологийн тоног төхөөрөмж, барилга, байгууламж бүхий иж бүрдлийг;

4.1.10. **“тээвэр зуучлалын үйлчилгээ”** гэж тээвэр зуучлалын гэрээний дагуу тээвэрлэлтийг зохион байгуулах болон тээвэрлэлтийн шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэх үйлчилгээг;

4.1.11. **“логистик”** гэж хэрэглэгчийн хэрэгцээ шаардлага, зорилтод нийцүүлэн тээвэрлэлт, үйлчилгээ, мэдээлэл, санхүүгийн урсгалыг эхлэх цэгээс зорилтот цэг хүртэл хамгийн үр ашигтай шилжүүлэлт ба хадгалалт, төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын нэгдмэл үйл ажиллагааг;

4.1.13. **“тээврийн мэргэжлийн байгууллага”** гэж тээвэрлэлтийн үйл ажиллагааг мэргэжлийн үндсэн дээр эрхлэх, удирдан зохион байгуулах, хяналт тавих, судалгаа, шинжилгээ хийх үүрэг бүхий хуулийн этгээдийг;

4.1.14. **“тээврийн аюулгүй байдал”** гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд хохирол учруулахгүйгээр тээвэрлэлтийг зохион байгуулах нөхцөл хангагдсан байдлыг;

## **5 дугаар зүйл. Тээврийн үйл ажиллагааны үндсэн зарчим**

5.1. Тээврийн салбарын үйл ажиллагаанд дор дурдсан зарчмыг баримтална:

5.1.1. Харилцан уялдаатай, нэгдмэл байх;

5.1.2. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, зах зээлийн эрэлтийг хангасан байх;

5.1.3. Үр ашигтай, тогтвортой, хүртээмжтэй байх;

5.1.4. Аюулгүй байдлыг хангасан байх;

5.1.5. Байгаль, хүрээлэн буй орчинд ээлтэй байх;

5.1.6. Өмчийн бүх хэлбэрийг хүлээн зөвшөөрөх.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТЭЭВРИЙН ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТ**

### **6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх**

6.1. Монгол Улсын Их Хурал тээврийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1. Тээврийн талаарх хууль батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох;

6.1.2. тээврийн хөгжлийн нэгдсэн бодлого, хөтөлбөр батлах;

6.1.3. тээврийн талаарх олон улсын гэрээ, хэлэлцээрийг соёрхон батлах;

6.1.4. тээврийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах;

## **7 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх**

7.1. Засгийн газар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1. тээврийн талаарх хууль, хууль тогтоомж, төрийн бодлого хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

7.1.2. тээврийн нэгдсэн сүлжээний тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх;

7.1.3. тээврийн хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах төлөвлөгөөг батлах;

7.1.4. хүн амын нутагшил, суурьшлын онцлог, нийтийн тээвэр ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй орон нутгийн тээврийн чиглэлд зорчигч, шуудан тээвэрлэлтэд нөхөн төлбөр олгох асуудлыг шийдвэрлэх;

7.1.5. тээврийн дэд бүтцийн газар эзэмшигчийг газрын төлбөрөөс чөлөөлөх, хөнгөлөх асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх;

7.1.6. Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх журам, нутаг дэвсгэрээр дамжуулан тээвэрлэхийг хориглосон барааны жагсаалт батлах;

7.1.7. Тээврийн хяналтын улсын дүрмийг батлах;

7.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

## **8 дугаар зүйл. Тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх**

8.1. Тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1. тээврийн асуудлаар Засгийн газраас эрх олгосны дагуу холбогдох улстай гэрээ, хэлэлцээ байгуулах;

8.1.2. тээврийн мэргэжлийн байгууллагын орон тоо, бүтэц, зохион байгуулалт, дүрмийг батлах;

8.1.3. тээврийн хэрэгслийн үйлдвэрлэх, угсрах, засварлах, ашиглах, тээвэрлэлтийн үйл ажиллагаа, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, цуцлах, хүчингүй болгох журмыг батлах;

8.1.4. аюултай ачаа тээвэрлэх болон тусгай үүргийн тээвэрлэлт гүйцэтгэх журмыг эрх бүхий байгууллагын саналыг авч батлах;

8.1.5. хууль болон олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэлтийн төлбөртэй үйлчилгээний төрөл, хураамжийг тогтоох журмыг батлах;

8.1.6. тээврийн салбарын статистик, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, хөтлөх журмыг батлах;

8.1.7. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх;

## **9 дүгээр зүйл. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

9.1. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.1.1. тээврийн талаар төрөөс баримталж буй бодлогын талаар санал гаргах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

9.1.2. тээврийн салбарын дүрэм, журам, зааврыг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

9.1.3. тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг тогтоох, биелэлтэд хяналт тавих;

9.1.4. тээврийн аюулгүй байдлын нөхцөл, шаардлагыг тогтоох, эрх бүхий мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн баталгаажуулах;

9.1.5. тээврийн зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, шударга өрсөлдөөнийг бүрдүүлэх зохицуулалт хийх;

9.1.6. тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрх, зөвшөөрөл эзэмшигч хоорондын болон үйлчлүүлэгч хооронд гарсан маргааныг эрх хэмжээнийхээ хүрээнд хянан шийдвэрлэх;

9.1.7. тээврийн салбарт шударга бус өрсөлдөөн үүсэхээс сэргийлэх зорилгоор тариф, бүтээгдэхүүн, үйлчилгээний хэмжээ, гэрээний өөрчлөлтийг хянаж, санал, дүгнэлт гаргах;

9.1.8. тээврийн салбарт эрдэм шинжилгээ, судалгаа, шинжлэх ухаан технологи, инновацийг нэвтрүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавих;

9.1.9. тээврийн шинэ төрлийг хөгжүүлэх, судалгаа хийх, эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх;

9.1.10. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх;

## **10 дугаар зүйл. Тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг**

10.1. Тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

10.1.1. тээврийн хөгжлийн нэгдсэн бодлого болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

10.1.2. тээвэрлэлтийн үйл ажиллагааг зохион байгуулах;

10.1.3. тээврийн мэдээллийн нэгдсэн сан байгуулж, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;

10.1.4. тээврийн салбарт мөрдөх улсын стандартыг боловсруулж, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн эрх бүхий байгууллагаар батлуулах;

10.1.5. тээврийн нэгдсэн маршрут, цагийн хуваарийн төлөвлөлтийг батлах, хэрэгжилтэд хяналт тавьж, зохицуулалт хийх;

10.1.6. тээврийн аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг хангуулах ажлыг зохион байгуулах, хяналт тавих;

10.1.7. тээврийн дэд бүтцийг өргөтгөх, шинээр барих ажиллагаанд хяналт тавих;

10.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх;

## **11 дүгээр зүйл. Аймаг, нийслэлийн засаг даргын бүрэн эрх.**

11.1. Аймаг, нийслэлийн Засаг дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1. тээврийн тухай хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагын шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулах;

11.1.2. төрөөс тээврийн талаар баримтлах нэгдсэн бодлого, төлөвлөлтөд нийцүүлэн тухайн нутаг дэвсгэрт тээврийн талаар баримтлах бодлого, төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;

11.1.3. тээврийн шинэ төрлийг нэвтрүүлэхэд тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авах;

11.1.4. тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллагатай хамтран нутаг дэвсгэртээ тээврийн улсын хяналтыг хэрэгжүүлэх;

11.1.5. орон нутгийн тээвэрлэлтийг тухайн нутаг дэвсгэрт зохион байгуулах, зохицуулах;

11.1.6. хүн амын нутагшил, суурьшлын онцлог, нийтийн зорчигч ба шуудан тээвэрлэлтийн хэрэгцээнээс шалтгаалан өрсөлдөх боломжгүй орон нутгийн тээврийн чиглэлд нийтийн зорчигч, шуудан тээвэрлэлтэд нөхөн төлбөр олгох нөхцөлтэйгээр тээвэрлэгчтэй гэрээ байгуулж, гүйцэтгүүлэх;

11.1.7. байгалийн гамшиг, сүйрэл, ослын хор уршгийг арилгах, тээврийн дэд бүтцийн хэвийн тасралтгүй үйл ажиллагааг хангахад хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд тээвэрлэлтийг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;

11.1.8. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

11.2. Аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд тээврийн асуудал хариуцсан алба байна.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТЭЭВЭРЛЭЛТ**

### **12 дугаар зүйл. Тээврийн төрөл**

12.1. Тээвэр дараах төрөлтэй байна.

- 12.1.1. автотээвэр
- 12.1.2. агаарын тээвэр
- 12.1.3. далайн тээвэр
- 12.1.4. төмөр замын тээвэр
- 12.1.5. усан замын тээвэр
- 12.1.6. бусад

12.2. Тээврийн тодорхой төрлийн харилцааг энэ хууль болон тухайн төрлийн тээврийн хуулиар зохицуулна.

### **13 дугаар зүйл. Тээвэрлэлтийн үйл ажиллагаа**

13.1. Тээвэрлэлтийн үйл ажиллагаа дараах төрөлтэй байна.

- 13.1. дагнасан тээвэрлэлт
- 13.2. холимог тээвэрлэлт

13.2. Дагнасан тээвэрлэлтийн үйл ажиллагаанд тээврийн нэг төрлөөр хийгдэх тээвэрлэлт хамаарна.

13.3. Холимог тээвэрлэлтийг нэг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх ба энэхүү гэрээний дагуу хоёр ба түүнээс дээш тээврийн төрөл дамжуулан гүйцэтгэх тээвэрлэлт хамаарна.

### **14 дүгээр зүйл. Тээврийн логистикийн үйлчилгээ**

14.1. Тээврийн логистикийн үйлчилгээнд тээвэр зуучлалын болон терминалын үйлчилгээг хамааруулна.

14.2 Тээвэр зуучлалын үйлчилгээ дараах төрөлтэй байна.

- 14.2.1. олон улсын тээвэр зуучлалын үйлчилгээ
- 14.2.2. дотоодын тээвэр зуучлалын үйлчилгээ

14.3. Тээвэр зуучлагч нь үйлчлүүлэгч болон тээвэрлэгч хооронд дараах үйлчилгээг үзүүлнэ.

14.3.1 тээвэр зуучлагч нь тээвэр зуучлалын гэрээг үйлчлүүлэгчтэй байгуулж ачааг хүлээн авч, хүлээлгэн өгөх, тээвэрлэлтийн гэрээг тээвэрлэгчтэй байгуулж ачааг тээвэрлүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

14.3.2. тээвэрлэгчийн тогтоосон үнэ тарифыг тээвэрлүүлэгчтэй тохиролцох;

- 14.3.3. тээвэрлэлтийн даатгалтай холбоотой баримт бичиг бүрдүүлэх;
  - 14.3.4. гаалийн баримт бичигтэй холбоотой баримт бичиг бүрдүүлэх;
  - 14.3.5. үйлчлүүлэгчид тээвэрлэлтийн явц, ачааны байршлын талаар мэдээлэл өгөх;
  - 14.3.6. агуулахын үйлчилгээ үзүүлэх;
  - 14.3.7. бусад нэмэлт үйлчилгээ.
- 14.4. Тээвэр зуучлалын үйлчилгээг эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ.

### **15 дугаар зүйл. Терминалын үйлчилгээ**

- 15.1. Терминалын үйлчилгээ нь дараах төрөлтэй байна.
- 15.1.1. ачааны терминал
  - 15.1.2. зорчигчийн терминал
- 15.2. Ачааны терминал нь ачааг цуглуулах, хүлээн авах, хадгалах, боловсруулах, ачиж буулгах, мэдээлэл дамжуулах, солилцохтой холбогдсон үйл ажиллагаанд зориулагдсан байгууламж байна.
- 15.3. Зорчигчийн терминал нь зорчигчийг нэг тээврийн хэрэгслээс нөгөө тээврийн хэрэгсэлд шилжин суух, зорчих нөхцөлийг бүрдүүлсэн үйлчилгээний барилга байгууламж байна.

### **16 дугаар зүйл Тээврийн логистикийн төв**

- 16.1. Тээврийн логистикийн төв нь тээврийн нэгдсэн сүлжээний зангилаа дээр орших, ачаа хуваарилалт, логистик үйлчилгээ, холимог тээвэрлэлттэй холбоотой үйл ажиллагаа, үйлчилгээг зохион байгуулахад зориулагдсан тусгай бүс байна.
- 16.2. Тээврийн логистикийн үйл ажиллагааны журмыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.
- 16.3. Тээврийн логистикийн үйлчилгээний ангилал, зэрэглэл, үйл ажиллагаа, үйлчилгээнд тавигдах шаардлагыг стандартаар тогтооно.

### **17 дугаар зүйл. Тээврийн дэд бүтэц**

- 17.1. Нийтийн хэрэгцээний авто зам, төмөр замын суурь бүтэц, агаарын хаалга, нисэх буудал болон тээврийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор байгуулсан тоног төхөөрөмж, барилга байгууламж төрийн мэдэлд байна.
- 17.2. Нийтийн хэрэгцээний авто зам, төмөр замын суурь бүтэц, нисэх буудлын газрыг газрын төлбөрөөс чөлөөлнө.

17.3. Энэ хуулийн 23.1, 23.2 дах хэсэгт зааснаас бусад тээвэрлэлтийн дэд бүтцийг өмчийн бусад хэлбэрээр байгуулж болно.

## **18 дугаар зүйл. Тээврийн даатгал**

18.1. Тээвэрлэгч нь болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх тээвэрлэгчийн хариуцлагын даатгалд заавал хамрагдсан байна.

18.2. Тээврийн хэрэгслээр зорчигч нь өөрийн амь нас, эрүүл мэндийг даатгуулах үүрэгтэй.

18.3. Ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч нь даатгалаар хүлээх хариуцлагын үнэлгээнээс илүү үнэлгээ бүхий ачаа тээвэрлэхийг хориглоно.

## **19 дүгээр зүйл. Тээврийн аюулгүй байдал**

19.1. Тээврийн аюулгүй байдал дараах төрөлтэй байна.

19.1.1. тээвэрлэлтийн аюулгүй байдал

19.1.2. тээврийн дэд бүтцийн аюулгүй байдал

19.2. Тээвэрлэлтийн аюулгүй байдлыг тээвэрлэгч хариуцах бөгөөд аюулгүй байдлыг хангаагүй, зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэлт гүйцэтгэхийг хориглоно.

19.3. Тээврийн дэд бүтцийн аюулгүй байдлыг өмчлөгч, эзэмшигч хариуцна.

19.4. Тээврийн аюулгүй байдалд тавигдах шаардлагыг тухайн тээврийн төрлийн хууль, дүрмээр тогтооно.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ТЭЭВРИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САН**

### **20 дугаар зүйл. Тээврийн цахим мэдээллийн нэгдсэн сан**

20.1. Монгол Улс тээврийн цахим мэдээллийн нэгдсэн сантай байна.

20.2. Цахим мэдээллийн нэгдсэн сан нь дараах дэд сангаас бүрдэнэ.

20.1.1. автотээврийн мэдээлэл

20.1.2. авто замын мэдээлэл

20.1.3. далай, усан замын тээврийн мэдээлэл

20.1.4. иргэний нисэхийн мэдээлэл

20.1.5. төмөр замын тээврийн мэдээлэл

20.1.6. тээврийн логистикийн мэдээлэл.

20.3. Тээврийн цахим мэдээллийн нэгдсэн сангийн ангилал, кодыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Үндэсний статистикийн хороо хамтран батална.

20.4. Тээврийн мэдээллийн нэгдсэн сангийн систем, техник технологи, програм хангамжийн ерөнхий шаардлага болон төрийн цахим мэдээллийн сан хариуцсан



байгууллагатай мэдээлэл солилцох журмыг тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

20.5. Цахим мэдээллийн сан нь төрийн мэдээллийн сантай мэдээлэл солилцох боломжтой байх бөгөөд төрийн цахим мэдээллийн сан хариуцсан байгууллагад дундын мэдээллийн сан үүсгэн ажиллуулна.

## **21 дүгээр зүйл. Цахим мэдээллийн сангийн аюулгүй байдал**

21.1. Тээврийн цахим мэдээллийн нэгдсэн сан, цахим сүлжээ үрэгдэх, устгагдахаас бүрэн хамгаалагдсан байх бөгөөд улсын онцгой объектын зэрэглэлтэй байна.

21.2. Тээврийн цахим мэдээллийн нэгдсэн сангийн нууцлал, хадгалалт, хамгаалалтын найдвартай байдлыг хангах үүргийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцана.

## **ТАВДУГААР БҮЛЭГ. ТЭЭВЭРЛЭЛТИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ШИНЖЛЭН ШАЛГАХ,**

### **22 дугаар зүйл. Тээвэрлэлтийн хяналт, шалгалт**

22.1. Тээврийн салбарын дотоодын хяналтыг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

22.2. Улсын байцаагчийг албан үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай дүрэмт хувцас, техник хэрэгслээр хангана.

### **23 дугаар зүйл. Тээвэрлэлтийн осол зөрчлийг шинжлэн шалгах**

23.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой осол, зөрчлийг шинжлэн шалгах, ангилах, бүртгэх ажиллагааг хамруулна.

23.2. Шинжлэн шалгах үйл ажиллагааг хараат бус байдлаар тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх шинжлэн шалгах алба хэрэгжүүлнэ.

23.2. Монгол Улсад бүртгэлтэй тээврийн хэрэгсэл гадаад улсын нутаг дэвсгэрт осол, зөрчилд өртсөн үед шинжлэн шалгах ажиллагааг олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу гүйцэтгэх ба Монгол Улсын нэрийн өмнөөс шинжээч оролцоно.

23.3. Шинжлэн шалгах алба нь тээвэрлэлтийн аюулгүй байдлыг сайжруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор шинжлэн шалгах ажиллагааны аль ч үе шатанд Аюулгүй байдлын зөвлөмж гаргаж болно.

23.4. Шинжлэн шалгах албаны шинжээчийг аливаа этгээдийн гэм бурууг тогтоох зорилгоор захиргааны болон иргэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх болон шүүн таслах ажиллагаанд оролцуулахыг хориглоно.

23.5. Тээврийн осол, зөрчлийг шинжлэн шалгах эрх бүхий байгууллага түүний шинжээч хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь иргэн, хуулийн этгээд шаардлагатай туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

23.6. Тээвэрлэлтийн осол, зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааг Тээвэрлэлтийн осол зөрчлийг шинжлэн шалгах журмаар зохицуулна.

### **ЗУРГААДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ**

#### **24 дүгээр зүйл. Тээврийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

24.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24.2. Тээврийн хууль тогтоомж зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хариуцлага ногдуулсан нь иргэний хууль хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

24.3. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

#### **25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох**

25.1. Энэ хуулийг 2021 оны . . . дугаар сарын . . . –ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

### **ГАРЫН ҮСЭГ**

## ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖ

- Үндсэн хууль, энэ хууль
- **Тээврийн ерөнхий хууль /шинээр/**
- Автотээврийн тухай хууль
- Авто замын тухай хууль,
- Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хууль,
- Далай ашиглах тухай хууль
- Усан замын тээврийн тухай хууль
- Иргэний нисэхийн тухай хууль
- Төмөр замын тээврийн тухай хууль